



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.3.7 дахь заалт нэмсүгэй:

“6.3.7.мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын суралцагч, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;”

2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1.7 дахь заалтын “малчин,” гэсний дараа “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч” гэж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1.13 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.9.10, 29.13.5 дахь заалтын “мэргэжлийн” гэсний дараа “болон техникийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7 дахь заалтын дугаарыг “6.3.8” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.5-д заасан журмын дагуу гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9.4-т заасан байгууллагатай” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР